ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/15 Сайншанд

Сайн багш – Оюунлаг сурагч дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Сайн багш – Оюунлаг сурагч" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013030

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/15 дугаар тогтоолын нэгдүгээр
Хавсралт

САЙН БАГШ - ОЮУНЛАГ СУРАГЧ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2 дугаар зорилт, Өмнөговь аймгийн Засаг Даргын 2025-2028 оны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн 2 дугаар зорилтын 2.1 дэх хэсэг, Өмнөговь Аймгийн Сэврэй Сумын Засаг Даргын 2024-2028 Оны Үйл Ажиллагааны "Тогтвортой Хөгжсөн Сэврэй-2028" Хөтөлбөрийн 1-р бүлгийн 1-5, 10-20 дугаар заалтуудын хэрэгжилтийг хангах үүднээс тус хөтөлбөрийг боловсруулсан.

Хоёр. Хэрэгцээ шаардлага

2021-2024 оны хугацаанд Сумын Засаг Даргын "Хөгжил-100" хөтөлбөрийн хүрээнд "Сайн багш - Оюунлаг сурагч" дэд хөтөлбөрийг "Сургууль цэцэрлэгийн удирдлага, хөтөлбөр, үйл ажиллагааны түвшинд менежментийн шинэ орчин , нөхцөл, хандлагыг нэвтрүүлэн багш, ажиллагсад, суралцагчийн хөгжлийг дэмжин сургалтын орчин нөхцөлийг сайжруулан, чанар, үр дүнг нэмэгдүүлж улсын дунджаас дээгүүр хэмжээнд хүргэж, Сургуулийн Өмнөх Боловсрол, Бага, Дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг бүрэн хангахад оршино." Гэсэн зорилгоор 5 зорилт 58 заалттайгаар хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрөөс 1 заалт огт хэрэгжээгүй, 1 заалт 30 хувийн хэрэгжилттэй, бусад заалт хэрэгжилт сайтай байж 91.72 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнан ажилласан.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 4 жилийн хугацаанд боловсролын салбарт нийтдээ 6.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Давхардсан тоогоор 16 багш, 4 туслах багш, 8 ажилтан, 140 суралцагчид 52.3 сая төгрөгийн шагнал урамшууллыг олгоод байна. Суралцагчдын улс, бүс, олон улсын уралдаан тэмцээнд оролцоход зориулж 25.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь суралцагчдын хөгжлийг шинэ шатанд гарган тэдний амжилт болоод багш, ар гэрийн санхүүд тодорхой хэмжээний дэмжлэг болсон. Багш суралцагчдыг шилдэг сайн багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтдийн сургалтад суух, мэдлэг чадвараа ахиулах, хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Жишээлбэл: "Олимпиад математик төв"-ийн сургалт, "Багшлахуйн баясгалан" төвийн сургалт, "Medle.mn" цахим сургуулийн сургалт зэрэг үр дүнтэй сургалтыг зохион байгуулсан. Ингэснээр сумын цэцэрлэг, сургуулийн нэр хүнд өсөж аймгийн бусад сургуулийн багш нар туршлага судлах айлчлалаар ирэх тоо нэмэгдсэн төдийгүй сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь эрс сайжирч 5-с 2-р түвшинд буюу 2022 онд хангалтгүй 57,1, 2023 онд 77.3, 2024 онд 93.6 хувиар тус тус шалгагдан аймагтаа тэргүүлэх үзүүлэлтэд хүрээд байна.Мөн хөтөлбөр хэрэгжих хугацаанд сургуулийн стратеги төлөвлөгөө 2021 онд, Сумын дунд хугацааны бодлогын баримт бичиг 2022 онд тус тус хэрэгжиж дууссан бөгөөд бодлогын хувьд шилжилтийн он жилүүд байсан төдийгүй цар тахал, ган зудын нөхцөл байдлуудыг

даван туулах, зайны болон цахим сургалтын орчин нөхцлийг бий болгох, турших хэрэгжүүлэх, сургуулийн үйл ажиллагааны шинэ менежментийг хэрэгжүүлэхэд бодлогын баримт бичиг болж өөрийн үүргийг маш сайн гүйцэтгэсэн хөтөлбөр болсон.

Иймээс 2025-2028 оны Засаг Даргын мөрийн хөтөлбөрт "Сайн багш-Оюунлаг сурагч" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон билээ.

Гурав. Сайн багш-Оюунлаг сурагч 2025-2028 хөтөлбөрийн үзэл санаа

3.1 Цомхон зорилт, заалттай

3.2 Биелэгдэхүйц

3.3 Тодорхой

3.4 Уялдаа холбоотой

3.5 Алсын харааnd чиглэсэн

Гурав. Дэд хэсэг

Сумын Боловсролын салбарт баримтлах алсын хараа: 2023-2123 он хүртэлх 100 жилийн хугацаанд хатан сэврэй нутаг хүний хөгжлөөр тэргүүлэгч сум болно

1. 20 дугаар Цэцэрлэгийн алсын хараа:

Хүүхдийн хөгжлийн цогц байдлаар шийдсэн тохилог таатай орчинд эрүүл бие бялдартай, харилцааны зөв хандлагатай, дадал хэвшилтэй, бүтээлч, эх оронч зөв монгол хүүхэд бэлдэнэ.Техник дэвшлийн эрин зуунтай хөл нийлүүлсэн хүмүүнлэг энэрэнгүй хөгжсөн багштай байна.

2. 20 дугаар цэцэрлэгийн Эрхэм зорилго:

Хүүхдийн онцлогийг илэрхийлж олон талт арга зүйг ашиглан хүүхэд бүрийг асран хамгаалах, хөгжүүлэх, чанартай тэгш хүртээмжтэй сургуулийн өмнөх боловсролыг эзэмшүүлнэ. Хүүхэд бүрийг сэтгэлтэй, өөртөө итгэлтэй насан туршдаа суралцах чадвартай үндэсний өв соёлыг дээдэлсэн иргэн болж төлөвшихөд эцэг эх, асран хамгаалагчид, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг эрхэмлэн дээдэлнэ.

3. Ерөнхий боловсролын Сургуулийн алсын хараа:

Суралцагч Өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, өөрийн удирдлагатай тасралтгүй суралцдаг, ёс зүйтэй иргэн болон хөгжинө.

4. Ерөнхий Боловсролын Сургуулийн эрхэм зорилго:

Байгаль экологийн зөв хандлагатай, эрүүл мэндээ анхаарах дадал хэвшилтэй, цахим ур чадварыг амьдрал ахуйдаа хэрэглэх мэдлэг чадвартай, хариуцлагатай, ёс зүйтэй суралцагч байх

Дээрх сум, цэцэрлэг, сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг биелүүлэх үндсэн нөхцөл, боломжийг бүрдүүлэх нь сумын бодлогын тэргүүлэх зорилтуудын нэг болж байна.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго

Цэцэрлэг, сургуулийн тогтвортой байдлыг ханган, бие даан хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлэн, багш суралцагчдын хөгжилд дэмжлэг үзүүлэх, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад оршино.

Тав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа

5. Зорилт:

5.1. Суралцагчийн чанартай боловсрол эзэмших, хөгжих нөхцөлийг бүрдүүлж олон талт үйл ажиллагаа зохион байгуулах

5.2. Сум орон нутгийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаагаар суралцагч хүүхдүүдийг хөгжүүлнэ

5.3. Сурагч, багш солилцоог хэрэгжүүлэн, гадаад дотоодод суралцах, туршлага судлах боломжоор хангана.

5.4. Багш суралцагчийн ололт амжилтыг урамшуулан дэмжинэ

5.5. Шаардлагатай хөрөнгө оруулалт, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангана

5.1.1 Суралцагчийн чанартай боловсрол эзэмших, хөгжих нөхцөлийг бүрдүүлж олон талт үйл ажиллагаа зохион байгуулах 1-р зорилтын хүрээнд

5.1.2 Сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт 2025,2026 онуудад шинэчлэл хийнэ

5.1.3 Секц, дугуйлангийн нэр төрлийг олшруулан хамрагдах хувийг нэмэгдүүлнэ.

5.1.4 Үнэлгээний программ хангамжийг хэвийн ажиллуулж, хөндлөнгийн үнэлгээг сайжруулна

5.1.5 Хүүхэд хамгааллын ажлыг сайжруулан, олон нийтийн оролцоог хангана.

5.1.6 Массын сургалтыг сайжруулах талаар анхаарч ахиц гаргана.

5.1.7 Сургууль, цэцэрлэгийн Суралцагчдад зориулсан зуны, хувилбарт болон бусад сургалтыг явуулах, сургагч багш нарыг урин ажиллуулах

5.1.8 Багш нарын тасралтгүй хөгжлийг хангах зорилгоор сургагч багш, сургалтын байгууллагатай хамтран ажиллах, багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, арга зүй, туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хэвлэн нийтлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах.

5.1.9 Эрүүл мэндийн боловсрол, эрүүл ахуйн дадал хэвшлийг олгох сургалт үйл ажиллагааг зохион байгуулна.

5.1.10 Цэцэрлэгийн аливаа үйл ажиллагаанд албан байгууллагууд ээлжлэн унаагаар үйлчлэх

5.1.11 Суралцагчийн чанартай боловсрол эзэмших, хөгжих нөхцөлийг бүрдүүлж оюуны сорилго, бөхийн сорилго, спортын олон төрлөөр туршлага судлах уулзалт, хамтарсан бэлтгэл зохион байгуулна

5.2 Сум орон нутгийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаагаар суралцагч хүүхдүүдийг хөгжүүлэх 2-р зорилтын хүрээнд

5.2.1 Суралцагчдын байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх, экологийн зөв чиг хандлагыг төлөвшүүлэх, монгол ёс заншил, өв уламжлалыг дээдлэх, хөдөлмөрч, бүтээлч хандалга бий болгох, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд анхаарч сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, аялалт хичээл үйл ажиллагааг зохион байгуулах, тодорхой санхүүжилтийг шийдвэрлэх

5.2.2 Сумын дунд хугацааны бодлогын бичиг баримтад тусгагдсан ажлуудыг шат дараалалтай хэрэгжүүлнэ

5.2.3 Сум орон нутгийн эрдэмтэн мэргэд, үе үеийн төгсөгчдийг сум, сургуультай эргэх холбоог сайжруулан, тэдний эрдэм мэдлэг, нээлт, судалгаа, бүтээлийг ашиглан цэцэрлэг, сургууль, суралцагчийн хөгжилд дэмжлэг болгон ашиглах, халамжлан хүмүүжүүлэх уриалгыг гаргаж, хэрэгжүүлнэ.

5.2.4 Аялал жуулчлалын бүс нутгийн давуу талыг суралцагчдын хэл сурах, хөгжих, шинэ санаачилга, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.2.5 Суралцагчийн хөгжлийн хавтсыг цэцэрлэгээс 9-р анги төгсөх хүртэл архивлан хөтлөх.

5.3 Сурагч, багш солилцоог хэрэгжүүлэн, гадаад дотоодод суралцах, туршлага судлах боломжоор хангах 3-р зорилтын хүрээнд

5.3.1 Суралцагчийг дотоодын зусланд амрах, суралцах, гадаад улсад түр сургалтад хамрагдах боломж нөхцлийг хангана.

5.3.2 Багш нарыг гадаад улсад суралцах, мэргэжил дээшлүүлэх нөхцөл боломжоор хангана

5.3.3 Сурагч солилцоо хөтөлбөрт хамруулна.

5.3.4 Багш солилцоо хөтөлбөрт хамруулна

5.4 Багш суралцагчийн ололт амжилтыг урамшуулан дэмжих 4-р зорилтын хүрээнд

5.4.1 Цэцэрлэг, сургуулийн аймаг, Улс, бүс, олон хот, гадаад орон, тив, дэлхийн хэмжээнд зохион байгуулагдаж буй Олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож буй суралцагч, багш нарт зардлын тодорхой хувийг шийдвэрлэх

5.4.2 Тухайн хичээлийн жилд аймаг, улс, бүс, олон улс, тив, дэлхийн хэмжээнд оюуны болон бусад төрлөөр амжилт гаргасан багш, суралцагчийн амжилтыг харгалзан тодорхой хэмжээнд урамшуулан алдаршуулна.

5.4.3 Тухайн жилийн тэргүүний багш, багшийн туслах, ажилтан, суралцагчийг шагнан урамшуулна.

5.5 Шаардлагатай хөрөнгө оруулалт, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах 5-р зорилтын хүрээнд

5.5.1 Дотуур байрны их засвар хийх

5.5.2 Сургууль цэцэрлэгийн стандартын агуулах барих

5.5.3 Цэцэрлэгийн их засвар хийх

5.5.4 Сургуулийн автобус болон фургон авто машины их засвар хийх

5.5.5 Химийн кабинет бодис урвалжтай болгох, хадгалах зориулалтын шүүгээг авах, тусгай зөвшөөрөл авах

5.5.6 Сургуулийн анги танхимуудад шаардлагатай тохижилт хийх. / Оюуны хөгжлийн танхимтай болох, Үндэсний бичгийн кабинет, Монгол хэл уран зохиолын кабинет, Мэдээлэл зүйн танхимыг нэмж тохижуулах,

Англи хэлний танхим тохижуулах, технологийн кабинетыг дэвшилтэт хэрэглэгдэхүүнээр хангах/

5.5.7 1, 2-р ангийн амралтын өрөөг тохижуулах

5.5.8 Цэцэрлэг сургууль Монгол уламжлал ёс заншлын өргөөг тохижуулах

5.5.9 Хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулах

5.5.10 Сургууль цэцэрлэгийн туршилтын талбайг бий болгох

5.5.11 Багш хөгжлийн төвийг тохижуулах

5.5.12 Цэцэрлэгийн хүүхдийн орыг солих

5.5.13 Цэцэрлэгийн цахим орчинг сайжруулах /интернет, ухаалаг дэлгэц, вэйлбүүк, хромбүүк, таблет/

5.5.14 Цэцэрлэгт Зөөврийн чанга яригч анги тус бүрт авах

5.5.15 Цэцэрлэг, сургуулийн Стем тоглоомын дэвшилтэт хэрэглэгдэхүүнээр хангах

5.5.16 Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх

5.5.17 Цэцэрлэгийн багш, суралцагчдын ширээ сандлыг шинэчлэх

5.5.18 Цэцэрлэгийн төсөлт агуулгын сургалтын хэрэглэгдэхүүний баяжилт хийх /сүү, ноос, тэдгээрийг боловсруулах хэрэглэгдэхүүн, хэв дардас гэх мэт

5.5.19 Дотуур байрны тавилга хэрэгслийг шинэчлэх /ширээ сандал, ор, шүүгээ/

5.5.20 Дотуур байрны охидын өрөөг тохижуулах

5.5.21 Дотуур байрны эцэг эхтэй уулзах өрөөг тохижуулах

5.5.22 Дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулах

5.5.23 Сургууль цэцэрлэгийн багш ажилчдын түрээсийн орон сууцыг бий болгох

Зургаа. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөлтийг Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон Бага, Дунд боловсролын тухай хууль, сайжруулсан хөтөлбөрийн 2 дахь хэвлэлийн агуулга, зорилго зорилт, суралцахуйн удирдамж, шинэчилсэн хөтөлбөр, Багш солилцоо, сурагч солилцоо, Чадварлаг багш хөтөлбөр, Боловсролын салбарын бусад төсөл хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан хууль тогтоомж, баримт бичиг, аймаг, сумын засаг даргын мөрийн хөтөлбөр,орон нутгийн хөгжлийн баримт бичиг, бусад төсөл хөтөлбөр, дэд хөтөлбөртэй нягт уялдаатай, харилцан зохицсон байдлаар хэрэгжүүлэх.

6.2 Хөтөлбөрийн зорилго үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог дэмжиж, өргөнөөр оролцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

6.3 Хөтөлбөрийн үйл ажиллагаа нь сургалтын орчин нөхцөлийг сайжруулах,багшийн хөгжил, суралцагчийн мэдлэг, чадвар , төлөвшилд ахиц дэвшил гаргаж, түүнийг бодитоор үнэлэхэд чиглэнэ.

6.4 Цэцэрлэг Сургуулийн бие даан хөгжих нөхцөл бололцоог бий болгож, менежментийн хөгжлийг дэмжих

6.5 Зорилт арга хэмжээг сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөө, М.Пунцагийн нэрэмжит ерөнхий боловсролын сургууль, 20-р цэцэрлэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган түргэн шуурхай хэрэгжүүлэх.

Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

7.1 Багш боловсон хүчнээр 100 хувь хангагдаж, багш нар мэргэжил ур чадвар, хандлагын хувьд өсөн нэмэгдэж, орон нутагт тогтвор суурьшилтай, үр дүнтэй, санаачлагатай ажиллах хүсэл сонирхолтой болсон байх. Багшийн ажлын гүйцэтгэл 71-с дээш хувьд хүргэнэ.

7.2 Хүүхдийн хөгжих нөхцөл боломж сайжирч суралцах, хөгжих, төлөвших олон талт үйлчилгээ буй болж, суралцагч сургалтын чанараа ахиулах, бие даан хөгжих хүсэл эрмэлзэлтэй болох, амьдрах арга ухаан болон хөдөлмөрт суралцах замаар хөдөлмөрийн үр шимийг мэдэрч,өөртөө итгэх итгэлтэй болно.

7.3 Хүүхдүүд Монгол өв уламжлал, ёс заншил болон орон нутгийнхаа түүх соёлыг мэдэж байгалийн онцлогийг судлан түүнийг хайрлан хамгаалах, бахархах үзэл хандлага төлөвшинө.

7.4 Хүүхэд хамгааллын ажил олон нийт, эцэг эхийн оролцоонд тулгуурласан бүх нийтийн үйл хэрэг болно.

7.5 Сургалтын чанар сайжирч ерөнхий боловсролын сургууль улсын дунджаас 0.3 хувиар ахиулна, сургуулийн өмнөх боловсрол өмнөх оноос 0.2 хувиар ахиулна.

7.6 Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт шинэ түвшинд хүрч тогтвортой өсөлтийг хангана.

7.7 Сургалтын орчин сайжирч багш суралцагч, ажилчны хөгжих таатай нөхцөл бүрдэнэ.

7.8 Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд менежмент, арга зүйн шинэ хандлага, арга барил, технологийг тогтворжуулан цаашид бие даан хөгжих нөхцөл бололцоог хангана.

7.9 Орон нутгийн түвшинд багш нарын хөгжлийг системтэй, тасралтгүй үйл ажиллагаагаар хангаж, багш удирдах ажилтны мэдлэг мэргэжил, хандлагыг дээшлүүлэх сургалтуудын чанар сайжирч , үйл ажиллагаа идэвхжин чанаржиж, өөрийн мэдлэг, ур чадвараа нээн харуулах боломж нэмэгдэн, урамшуулан дэмжсэнээр ажлын бүтээмж дээшилнэ

7.10 Сургууль, Цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар, бусад байгууллага иргэний хамтын ажиллагаа сайжирна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

Хөтөлбөр 2025-2028 оны хооронд хэрэгжинэ.

Ес. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт хэрэгжилтийг тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ

9.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Сумын засаг даргын тамгын газар, ерөнхий боловсролын сургууль, 20-р цэцэрлэг хамтран зохион байгуулна.

9.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлийн жилээр тооцож, санхүүгийн жилийн эцэс бүрээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан, үнэлгээг хийнэ.

9.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн Бодлогын хөгжлийн хорооны төлөөллөөр ахлуулан, сургууль, цэцэрлэгийн зөвлөл, сумын хүүхэд хамгаалах зөвлөл, мэргэжлийн байгууллагын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, эцэг эхийн зөвлөлийн төлөөллүүдийн оролцоотойгоор батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх бөгөөд шаардагдах зардлыг сумын тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Арав. Хөтөлбөрийн санхүүжилт

10.1 Улсын төсөв

10.2Орон нутгийн төсөв

10.3 Орон нутгийн хөгжлийн сан

10.4 Ерөнхий боловсролын сургууль, 20 дугаар цэцэрлэгийн төсвөөс хуульд заасан нэмэгдэл

10.5 Олон улс болон гадаад, дотоодын байгууллагуудын хандив, тусламжийн хөрөнгө

10.6 Салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр

10.7 Иргэд хувийн хэвшлийн дэмжлэг

10.8 Бусад

Арван нэг. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь Түвшин	Хүрэх түвшин			
				2025	2026	2027	2028
1	Мэргэжилтэй боловсон хүчнээр 100 хувь хангагдсан байна	Хувь	99%	100%	100%	100%	100%
2	Сурагчдын өхөглийг дэмжих зорилгоор дугуйлан секцийг үр дүнтэй хичээллүүлнэ.	Хамрагдах хувь	43%	48%	52%	57%	62%
3	Эх орны түүх соёл, байгаль хамгаалах, эх оронч үзэл төлөвшүүлэх, Монгол өв соёл, ёс заншлаа судлах чиглэлээр аялалт хичээл зохион байгуулна	Аялалт хичээл	15	13	13	13	13
4	Сургалтын чанарыг сайжруулах	Хувь	82,3%	82.6%	82.9%	83.2%	83.5%
5	Цэцэрлэг сургуулийн суралцагчдын дунд, олон талт үйл ажиллагаа зохин байгуулах	Үйл ажиллагааны тоо	4	4	4	4	4
6	Хүүхэд хамгааллын ажлыг тогтмол сайжруулж, бүх нийтийн оролцоог хангасан байна.	Үйл ажиллагааны тоо	8	9	9	10	10
7	Сургалтын хөтөлбөр шинэчлэгдэн, орчин нөхцөл сайжирна	Үйл ажиллагааны тоо	5	5	5	6	8

8	Сургуулийн менежментийг сайжруулна	Тоо	1	3	2	1	3
9	Багшийн хөгжлийг тасралтгүй хангах	Тоо	3	2	2	3	2
10	Даалгаврын сангийн платпорм /программ хангамж/-г угсарч бүрэн ашиглана	Даалгаврын тоо	235	2000	3000	4000	5000

-oOo-

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/15 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт

САЙН БАГШ – ОЮУНЛАГ СУРАГЧ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч : Сумын Засаг дарга

Гишүүдэд:
- Засаг даргын орлогч
- Засаг даргын Тамгын газрын дарга
- Б.Алтанцэцэг (ИТХ-ын Төлөөлөгч, Нийгмийн бодлогын хөгжлийн хорооны дарга)
- 20 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
- Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
- Соёлын төвийн эрхлэгч
- Ерөнхий боловсролын сургуулийн Сургалтын менежер
- Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан
- 20 дугаар цэцэрлэгийн Арга зүйч
- Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн заах аргын нэгдлийн ахлагч
- Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч
- Ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн ахлагч
- Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхийн зөвлөлийн дарга
- Ерөнхий боловсролын сургуулийн Насан туршийн боловсролын багш
- Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан

Нарийн бичиг: Ерөнхий боловсролын сургуулийн захирал

-oOo-